

КОРПУСЫН ОЛОН ХЭЛНИЙ МАТЕРИАЛЫН САНД СУУРИЛАН ДИСКУРСТ ШҮҮМЖ ШИНЖИЛГЭЭ (CDA) ХИЙХ ТУХАЙД

Ш.Эгшиг¹

Summary: *Lots of texts can be gathered in a corpora and many research methods can be developed to draw conclusions from it. It is possible to consolidate a large database and determine regularities as well. Critical Discourse Analysis (CDA), which emerged in the second half of the twentieth century, is such a highly sophisticated tool that it is widely used not only in linguistics but also in many areas of the social sciences. This article discusses how to use the Critical Discourse Analysis in a multilingual corpora.*

Түлхүүр үг: *дискурс, шүүмж, хэлний материал, корпус, хэлэхүй, дискурсын шүүмж шинжилгээ*

Хэлшинжлэлийн корпус гэдэг нь тодорхой нэг зохиогчийн туурвин бичсэн бүхий л эх бичвэр эсвэл тодорхой сэдэвт судлагдахуунд хамаарах бүхий л эх бичвэрүүдийг нэг дор цуглуулсныг хэлдэг. Үүнийг хятадаар 语料库 буюу “хэлний материалын сан” гэж оноосон байдаг. Корпус хэлшинжлэл нь уг эхээрээ байгаа бичвэрийн хэлний материалд илэрч байгаа хэлийг судлахыг хэлдэг ажээ. Тухайлбал, дэлхийн гол гол шашны сургаал номлолын эх бичиг болох бурхны шашны их хөлгөн судар, шаштирын цоморлиг, библийн ариун судар, коран судар бол нэг нэг корпус буюу хэлний эх хэрэглэгдэхүүн болно. Тэгэхээр тухай тухайн судрын хэлийг судалж байгаа нь корпус хэлшинжлэлийн судалгаа болж таарч байна. Монгол судлаачдын хувьд сүүлийн хоёр зуун дамнуулан хийсэн корпус хэл шинжлэлийн хамгийн дорвитой томоохон судалгаа бол Монголын Нууц Товчоо (МНТ)-ны хэлний судалгаа юм. 2016 онд гарсан “Дэлхийд түгсэн МНТ”² гэдэг бүтээл нь МНТ-ны судалгааны мэдээллийг нэг дор нэгтгэсэн ажил болсон юм. Үүгээр МНТ-ны судалгааны санг жагсаан толилуулсан билээ. Энэ мэтчилэн аль нэгэн тодорхой сэдвийн дор эх бичигт суурилсан хэлшинжлэлийн янз бүрийн судалгааны хэлний материалын сан хаа сайгүй үүсч байдаг байх нь. МНТ-ны хэлний судалгаанд МНТ-ны орчуулгын судалгаа жинтэй хувийг эзэлдэг. МНТ-ны одоогоор олдоод буй эх нь хятад үсгээр монгол хэлээрх агуулгыг галиглаж бичсэн байдалтайгаар байгаа эх юм. Энэ нь уг корпусын өөрийнх нь онцгой тал юм. Ийм эхийг янз янзаар хөрвүүлэн орчуулж судлах нь уг зохиолын хэлийг тодруулан гаргах нэг арга зам нь болдог. Чингэснээр уг зохиолын утга санаа, илэрхийллийг тодруулж байгаа хэрэг болно. МНТ-ны монгол дуудлагаар хятад үсгээр буй эхийг монгол бичгээр буулгасан нь энэ зохиолыг жинхэнэ монгол зохиол болгох үйл явц

¹ Доктор /Ph.D./, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим

² Дэлхийд түгсэн Монголын Нууц Товчоо, УБ, 2016, Мөнхийн үсэг ХХК

байв. Уг нь энэ бүтээл анх монгол хэлээр зохиогдсон нь дамжиггүй ч, нэгэнт тэрхүү монгол бичгийн эх бичиг олдоогүй байгаа тул уг зохиолыг монгол бичгээр буулгасан Цэнд гүнгийн ажил нь монголчуудын МНТ-ны анхдагч хөрвүүлэг байсан бөгөөд эдүгээ XXI зууны эх хүртэл гүүш Лувсанданзангаас эхлэн МНТ-г дотоод гадаадын олон эрдэмтэн судалжээ. Энэ бүх судалгаа бол МНТ хэмээх корпусыг бүрдүүлж байна. Энэ корпусын судалгаа нь МНТ зохиогдох үеийн монголчуудын хэл ярианы онцлогийг гаргаж болохуйц хэлний материал болно. Өөрөөр хэлбэл, дундад зууны үеийн монголчуудын үгийн санг гаргаад ирж болно, тухайн үеийн монголчуудын хэлний хэлзүйн онцлогийг тогтоож болно.

Яг үүнчлэн барууны ертөнцөд корпус хэлшинжлэлийн судалгаагаар XX зууны дунд үеэс толь бичиг зохиох анхны суурь корпусыг боловсруулж ирснээр өнөө цагт алдартай болсон, маш их тайлбар, жишээтэй толь бичгүүд зохиогдон гарчээ. Тухайлбал, ‘Cobuild corpus’ уугуул британий англи хэлээрх эх бичвэрээс гадна Хойд Америк, Шинэ Зеланд, Австрали, Өмнөд Африкийн БНУ болон Английн холбооны хамтын нийгэмлэгийн орны бүхий л утга зохиолын эхүүдийг цуглуулж сан бүрдүүлж “Англи хэлний банк”³ хэмээх санг багтаасан ‘Cobuild corpus’-ыг бий болгосон нь ‘Collins’ толийн эх үндэс болсон хэрэг. Энэ корпусын англи хэлний сан нийт 4 тэрбум гаруй үг, нийлэмж үгээс бүрддэг ба “Англи хэлний банк” сан бол үүнээс сайтар шүүж ялгаж авсан 650 орчим сая үг, үг хэллэгийн баазтай ажээ. Манайд ийм жишгээр бичил хувилбараар ажилладаг толь зохиогчид бий. Хятад хэлний нэртэй орчуулагч Д.Болдбаатар Монгол-Хятад, Хятад-Монгол толь бичиг гаргасан, энэ толь хятад хэл анхлан үзэж буй хүмүүст ихээхэн хэрэгцээтэй байдаг, харин мэргэжлийн болон гүнзгий шатны хятад хэлний үг хайхад хангалтгүй болоод ирдэг, энэ нь уг толийн хэлний материалын сан нь маш явцуу бага гэсэн үг юм. Д.Болдбаатар нэгэнт өөрт буй сангаа ашиглан мөн Монгол-Япон, Япон-Монгол толь бичиг гаргасан, тэр сангаар Монгол-Солонгос, Солонгос-Монгол толь гаргасан ч болно. Тэгэхээр корпус хэлшинжлэл бол хэрэглээний хэлшинжлэлд чухал байр суурийг эзэлдэг юм. Хэлний материалын санг бүрдүүлэх, үүнийг ашиглах нь дан ганц хэлшинжлэлээр тогтохгүй бусад нийгмийн ухааны практикт өргөн хэрэглэгддэг.

Ер нь корпус хэлшинжлэлд маш их мэдээллийг цуглуулаад үүнээс дүгнэлтэд хүрэх олон судалгааны аргыг үүсгэн боловсруулж болно. Их мэдээллийн санг нэгтгэн дүгнэж зүй тогтлыг тогтоох нь энэ ухааны гол зорилго ч байж болно. Тэгвэл тэдгээр судалгааны аргын нэг болох ‘дискурсын шүүмж шинжилгээ’ (Critical Discourse Analysis CDA)-ний талаар товч авч үзье. Дискурсыг “хэлэхүй”⁴ (*langage* F. de Saussure) гэж ойлгоход ч болмоор. Хэлшинжлэлийн нэгжийнхээ хувьд өгүүлбэрзүйн түвшнээс хальсан ойлголтыг илтгэдэг. Ялангуяа явцуу нэг ухааны бус нийгмийн нийтлэг хүрээнийхний дунд ашигладаг текст буюу эх бичвэрт энэ нь илүү тодорч танигддаг. Орчуулгын шүүмж судлал ба утга зохиолын шүүмж судлал зэрэг шүүмжийн олон судлал хөгжиж байна. Энэхүү

³ The Collins Corpus <https://collins.co.uk/pages/elt-cobuild-reference-the-collins-corpus>

⁴ Ferdinand de Saussure, (1916) *Place de la langue dans les faits de langage, Linguistique de la langue et linguistique de la parole*, Cours de Linguistique Générale, Payot & C, Lausanne-Paris, pp. 27-32, 36-40.

“дискурсыг шүүмжлэлтэйгээр шинжлэх” гэсэн нь тухайн дискурсыг зүгээр нэг шүүмжлэх тухай асуудал биш харин ерөнхий ойлголтыг заадаг гэж тайлбарлажээ. Тэгэхээр шүүмжлэлт сэтгэлгээгээр дискурст задлан шинжилгээ хийнэ гэсэн үг юм. Өнгөрсөн зууны сүүлээр анхлан Рожер Фоулер (Roger Fowler), Т.А фон Дейк⁵(Teun van Dijk), Норман Фэйерклаф⁶(Norman Fairclough), Рүт Водак (Ruth Wodak) нар энэ сэдвээр ярьж эхэлжээ. Ер нь “дискурсыг шүүмжлэлтэйгээр шинжлэх” гэдэг нь шинжилгээний арга хэрнээ нийгэм хэлшинжлэлийн дискурсыг судалдаг ухаан гэж Норман Фэйерклаф⁷ үзжээ. Нийгэм дэх оюун санааны хүч, үзэл суртал, сургаал номлол нь хэлээр хэрхэн илэрч хэрэгждэгийг судлах ухаан гэж бас хэлж болно. Тэрхүү дискурс нь эх бичвэр, яриа, видео контент, нийгмийн практик үйл ажиллагааг багтаасан ойлголт юм. Судалгааны аргазүйн хувьд нэг зүйлийг тодотгодог нь аливаа нийгмийн үйл ажиллагаа, практик үйлдэл дискурсээр хэлбэржиж, ямар нэг байдлаар хадгалагдан ул мөрөө үлдээдэг. Нэгэнт дискурсын хэлбэрт шилжсэн бол үүнийг хэлшинжлэлийн судалгааны аргаар судлах боломжтой. Дискурсын хэлбэрт шилжсэн нийгмийн үзэгдэл, практик үйл ажиллагаа нь эргээд нийгмийн практикт хэрхэн нөлөөлөхийг нь бас шинжилж болно. Тэгэхээр дискурсын шүүмж шинжилгээ нь хэлшинжлэлийн төдийгүй бусад шинжлэх ухааны ялангуяа нийгмийн шинжлэх ухааны юмс үзэгдлийн шүтэлцээг судлах ухаан болох юм. Үүнд шинжилгээний нарийн тогтсон арга, аргачлал гэж байдаггүй, тухайн судалгааны оногдохуунаас хамаарч судалгааны аргаа сонгон тохируулдаг, чингэхдээ голдуу хэлшинжлэлийн дискурсын шинжилгээний аргыг хэрэглэдэг байна.

Сүүлийн үед корпус хэлшинжлэлийн хэлний материалын сантай энэхүү дискурсын шүүмж шинжилгээ хэмээх нийгэм хэлшинжлэлийн ухааныг уялдуулж судалдаг болжээ. Ямар нэгэн чиглэлийн юм уу ямар нэг сэдэвт хамаарах эх бичвэрийн сангийн тухай өмнө ярьсан, маш их мэдээллийг нэг дор цуглуулах тусам түүнээс гарах зүй тогтол, дүгнэлтийн үнэн зөв байх магадлал өсөх нь дамжиггүй. Жишээ нь, гүүглийн орчуулгын программаас англи-япон, англи-хятад хэлний хооронд хийсэн орчуулга нь хүн уншихад түлхүү ойлгомжтой, хэлзүйн хувьд зөв, боломжийн найруулгатай орчуулга гарч байгаа мэт санагддаг, харин англи-монгол, монгол-япон хэлний орчуулга нь утга ойлгомжгүй, найруулга тааруу, зүгээр л хэсэг үгийн цуглуулбар болсон мэт санагддаг, энэ нь санах ой дахь монгол хэлний сан нь цөөн үг хэлхэцтэйг харуулж байгаа хэрэг. Харин “англи хэлний банк” хэдэн зуун сая үг хэлхэц бүхий сантай, япон хэлний сан мөн тийм хэмжээтэй бүрдсэн бол компьютер тэр олон хэлхэцээс хамгийн их нийцтэйг нь төвөггүй тоолж олоод гаргаад ирнэ гэсэн үг. Чингэхээр нийгмийн практикт болж буй олон үйл явдлыг дискурст хувирсных нь дараа тухайн сэдэвт хамаарах бусад олон тохиолдлын дискурсын хэлний материалын сантай хамт юм уу

⁵ Van Dijk, T.A.(1993). *Elite Discourse and Racism*. Newbury Park, Calif: Sage Publications. Inc

⁶ Fairclough, Norman. (1989). *Language and Power*. New York: Longman. [1]

⁷ Karin Zotzmann and John P.O'Regan (2016), *Critical Discourse analysis and Identity*, The Routledge Handbook of Language and Identity, Routledge, London & New York, p.114
Systematic Functional Linguistics and Critical Discourse Analysis: Studies in Social Change (2004), Lynne Young and Claire Harrison, London & New York, p.2

дангаар нь хэлшинжлэлийн империк юм уу, тооцооллын тохиромжтой гэж үзсэн аргачлалаараа боловсруулалт хийж, тухайн нийгмийн үзэгдлийг үнэлж болно.

Дискурсын шинжилгээ нь нийгмийн тодорхой нөхцөл байдалд шүүмжлэлтэй хандах, ил болон далд утгын мөн чанарыг нь олж илрүүлэх хандлагыг тогтоож ч болох юм. Чингэхдээ голлон аливаа зүйлд тайлбар хийх, задлан шинжилж дүгнэлт хийхэд тулгуурладаг. Зарим судлаачид дискурс нь таамаглал, далд утган дээр суурилсан бодит утга гэж үзсэн байдаг. Дискурсын шинжилгээгээр судлаачид судалж буй зүйлийнхээ семантик түвшин болон мөн түүнчлэн прагматик түвшний аль алинд нь ямар утга санаа үүсч байгааг тодорхойлон тайлбарлахыг хичээдэг ажээ.

Дискурст шүүмж шинжилгээ хийснээр

- Шинжлэх ухааны салбар дундын суурь зарчим, чиг баримжааг тогтоож болно.
- Судалж буй нийгэм улс төрийн үйл явцыг дискурсын хэлбэрт оруулснаар энэ үйл явцад нөлөөлж байгаа ил, далд нөлөөллийн хүчин зүйлийг тодруулан гаргаж болно.
- Шинжилгээний үр дүнгээ нийгэмд болж буй үйл явцыг эерэг тал руу нь хандуулах хүчин зүйл болгон хувиргаж болно.

Эдгээр нь уг дискурсын шүүмж шинжилгээний ач холбогдолтой тал нь юм.

Орчин үед улс төрийн дискурст энэ шинжилгээний үр дүнг ихээр ашиглах боломжтой. Дискурсын шүүмж шинжилгээний тухай ухааныг үндэслэгчдийн нэг Норман Фейерклафын (Fairclough, 1993:133) дискурсын 3 хэмжээст загварыг⁸ судлаачид ихээхэн ашиглаж байна. Энэ загвар нь дараах гурван түвшний шинжилгээнээс бүрддэг.

1. Эхийг шинжлэх
2. Дискурсын түвшинд шинжлэх
3. Хам сэдвийн буюу нийгмийн орчинд шинжлэх


Үүнийг ойлгож ухахын тулд энгийн жишээ авч болох юм. Кино зохиол бол эх бичвэр, кино зураг авч, киног бүтээх нь дискурсын түвшинд очиж байгаа бөгөөд уг кино гарсны дараа нийгэмд нөлөөлж байгаа нөлөөлөл нь энэ киноны тухай санал сэтгэгдэл, киноны шүүмж, тэр бүү хэл ихээхэн ашиг орлоготой кино бол нийгэмд төдийгүй эдийн засагт ч нөлөөлдөг. Хэл судлаачид кино зохиолыг эх хэрэглэгдэхүүн болгон эхийн шинжилгээ хийх бүрэн боломжтой, кино бүтээх үеийн олон үйлдэл, тухайн үеийн улс төр, нийгэм, цаг уурын нөхцөл байдал зэрэг юуг нь ч судалгааны оногдохуун болгон шинжилж болох юм, киноны анхны үзэл санаа нь бүтээх үеийн нөхцөл байдалтайгаа нөхцөлдсөөр нийгмийн орчинд огт

⁸ Fairclough, Norman (1993) *Critical discourse analysis and the marketization of public discourse: Universities. Discourse and Society*, 4 (2), 133-168.

Fairclough Norman. (1995) *Text and Language, Critical Discourse Analysis*. (London, Longman), p.9

Tian Xinling, (2018) *Critical Discourse Analysis of News Reports— Based on the Guardian News Report of China's Military Parade to Mark the 70 Years of Second World War, Theory and Practice in Language Studies*, Vol. 8, No. 4, p.434.

кино гараагүй үеийг бодвол нөлөөлсөөр, нийгмийн орчныг өөрчилж, үр нөлөөгөө тарих нь дамжиггүй. Чингээд чухам дискурсын шүүмж шинжилгээг аль ч түвшинд хийх байсан ч, бүхий л мэдээллийг бичигт буулгаж болно, нэгэнт бичгийн хэлбэрт шилжсэн бол үүнийг шинжилгээний ямар ч арга хэрэгсэл ашиглан шинжилж болно. Дискурсын шүүмж шинжилгээний загварыг хамгийн энгийнээр дараах байдлаар дүрсэлж болох юм.



Зураг 1. Норман Фейерклафын дискурсын 3 хэмжээст загварын бүдүүвч

Энэ загвараас харахад, алив үзэгдэл, үйл явцын эх бичвэрийн түвшин ба хам сэдвийн (нийгмийн) түвшингийн нийгэмд тархах цар хүрээ, нөлөө нь адилгүй болох нь харагдаж байна. Дискурсын түвшин нь дундаж бөгөөд, эх бичвэрийн түвшин ба нийгмийн орчин хоёрыг холбож өгдөг, энэ түвшингүйгээр энгийн эх бичвэр нийгэмд нөлөөлөх, нийгэм рүү шилжих аргагүй ажээ.

Сүүлийн үед дискурсын шүүмж шинжилгээгээр хэвлэлийн мэдээ, давтамжтай хийдэг хэвлэлийн хурал, төрийн тэргүүн, төрийн зүтгэлтний хэлсэн үг, олон нийтийн сүлжээнд тавьсан санал сэтгэгдэл зэрэгт уг шинжилгээг хийж нийгмийн болон төрийн бодлогын байдлыг тандах, нийгмийн сэтгэлзүй, төрийн бодлогыг хэрхэн үнэлж байгаа зэргийг үнэлэн тогтоодог болжээ.

Мөн орчуулгазүйд хоёр болон олон хэлний материалын санд суурилсан дискурсын шүүмж шинжилгээг хийж байна. Монголын нууц товчоо (МНТ) өнөөгийн байдлаар дэлхийн 30 гаруй гадаад хэлнээ орчуулагдсан юм⁹. Зарим хэлэнд хэд хэдэн орчуулгын хувилбар¹⁰ (Н.Мөнх, 2015: 108-110) бий. Монголын Нууц Товчооны олон хэлний орчуулгын байдалд хэлний олон судалгаа гарч байна. Цэнд гүний монгол хөрвүүлэг, С.А.Козины орос орчуулга, П.Пеллио, Мари-Доминик Эвен ба Родико Поп нарын франц орчуулга, Э.Хэниш, В.Хайсиг нарын герман орчуулга, Ш.Озавагийн япон орчуулга, Л.Лигеттийн мажар хэлний орчуулга, Ф.В.Кливес, Онон Өргөнгөө нарын англи орчуулга, С.Калужинскийн польш хэлний орчуулга¹¹ гээд бүхий л орчуулга аяндаа эх бичвэр болж судалгааны эх хэрэглэгдэхүүн болно. МНТ хэмээх корпус дотроо анхны хятад бичгээрх монгол хэлний эхээс олон хэлний орчуулгаар салбарлан эх бичгийн арвин их хэрэглэгдэхүүн буй болжээ. Эдүгээ дискурсын шүүмж судалгааны хувьд түвшинг ахиулан дискурсын ба хам сэдвийн түвшин буюу нийгмийн орчинд шинжилгээг хийж болно. Зөвхөн монгол хэлний хүрээгээр хязгаарлан дискурсын

⁹ (2016) Өргөл үг, Дэлхийд түгсэн Монголын Нууц Товчоо, МУИС, МСХ, УБ, Мөнхийн үсэг ХХК, 9-р тал.

¹⁰ Н.Мөнх (2015) МНТ-ы өнгө, зүсэм бүхий хүний нэрийн франц орчуулга, Гадаад хэл соёл судлал, МУИС ЭШБ, Боть 19(430), 108-110 тал.

¹¹ С.Галсан (2006), Чамбай эрдэмтний чамбайхан олз, Монголын нууц товчоо зохиолын гадаад орчуулга, УБ, Бемби сан ХХК, 27 тал.

шүүмж шинжилгээ (CDA) хийж болно, хэрэв тийм шинжилгээ хийвэл, Төрийн ордонд залсан МНТ-г хэрхэн бүтээсэн, ямар эхийг баримталсан, хэн хэн гэх эрдэмтний судалгаа ба санал гарсан, ямар түүхт ойн хүрээнд хэрэгжсэн, энэ төрийн хүндэтгэлийн үйл ажиллагаа нийгэмд ямар нөлөө үзүүлсэн, монгол үндэстний сэргэн мандалд хэрхэн тусгалаа олсон гээд шинжилгээг хийж үр дүнг томъёолон гаргаж болох юм. Харин олон хэлний материалд суурилан шинжилгээ хийх бол бас судалгааны арга, аргачлал, хамрах хүрээ нь ямар байхыг урьдаар тогтоож, хэрэгтэй үр дүнгээ гаргаж авч болно, энэ тохиолдолд орчуулгазүйн онол, судалгааны аргыг оруулж тооцох зайлшгүй байдал үүсэх нь дамжиггүй. Тухайлбал, МНТ-ны агуулгаас сэдэвлэн, гадаадад олон контент гарчээ. Тэдгээр контент тухайн улсын хэлээр МНТ орчуулагдсан учраас зохиогдсон байж таарна. Уран сайхны кино, баримтат кино, хүүхэлдэйн кино, комикс-зурагт ном хүртэл гарсан байна. Оросын нэрт кино найруулагч С.Бодровын Чингис хааны тухай “Монгол”¹² кино 2007 онд гарсны дараа монголын үзэгчдийн болон монголын кино судлаачдын дунд өргөн хэлэлцүүлэг өрнөсөн, олон талаас нь шүүмжилсэн, шүүмжилсэн гэдэг нь “шүүмжлэх” гэдэг шууд утгаар бус, утга зохиолын шүүмж хэмээх утгаар олон талын санал бодол гарч, шүүн хэлэлцсэнийг хэлж байгаа юм. Оросын кино судлаач болон үзэгчид энэ киног хэрхэн үнэлсэн, шүүмжилсэн болон бусад улсын монгол судлаачид ба үзэгчдийн шүүмж ямар байсан зэргийг шинжилж үзвэл сонирхолтой үр дүн гарах болно. Үүнтэй адил БНХАУ-д 2004 хийсэн “Чингис хаан” телевизийн гучин ангит киног дискурсын шүүмж шинжилгээгээр шинжилж үзвэл бас нэг үр дүнг үзүүлнэ. Японы кино найруулагч Шиничиро Савайн бүтээсэн өөр нэгэн “Чингис хаан” киног бас ингэж шинжилбэл ямар байх бол? Чингис хааны тухай уран сайхны хэтрүүлэгт киног 2018 онд Хятадын зах зээлд зориулан ашиг хөөцөлдөн хийсэн тухайгаа ч саяхан найруулагч нь ярьсан¹³ байна лээ. Чингэхээр энэ бүх контент бол МНТ-ны уг эхээс үүсч бүтсэн, гэвч уг эх нь монгол үндэстний юм боловч, тэр бүхэнд контент бүтээсэн улс үндэстний хэл соёлын нөлөө зайлшгүй тусна, энэ нь яриангүй орчуулгын хэлээр дамжин тухайн улс үндэстний оюун сэтгэхүйд хүрсэн шүү дээ. Тэгээд тэр үндэстний сэтгэхүйн шүүлтээр дамжиж уран бүтээл болж хэлбэржсэн, үүнийг буцаагаад монгол үндэстний нүд чихээр оруулахад ямар сэтгэгдэл төрөх нь мөн л олон хэлний материалын харилцан бие биендээ шилжин хэлбэржсэний улмаас үүссэн гажилт, нөлөөт байдлын үр дүн байна. Дискурсын шүүмж шинжилгээний хувьд харин хатуу тогтсон судалгааны арга зарчим гэж байдаггүй, үүнийг нийгмийн судалгааны ямар ч арга, аргачлалыг сонгон хийх боломжтой байдаг гэдгийг энэхүү нийгэм хэлшинжлэлийн онолчид угаас хэлсэн билээ.

Нэг хийсэн судалгааны талаар ярья. БНХАУ-д Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон уг их хурлын чуулган тодорхой дүрмээр жилд хоёр удаа чуулдаг. Хавар, намрын чуулганы дараа Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд гадаад дотоодын сурвалжлагч нарт улс орны эдийн засаг, нийгмийн байдал,

¹² Сергей Бодров-старший снял фильм о Чингисхане <https://ria.ru/20070823/73997546.html>

¹³ “Чингис хаан” уран зөгнөлт кино маргаашаас эх газрын Хятадын кино театруудад гарч эхэлнэ, 2018-04-27 <https://montsame.mn/mn/read/88170>

хэрэгжүүлэх бодлого шийдвэрийг танилцуулаад, тэдний асуултад хариулдаг уламжлалтай. Энэ хэвлэлийн бага хурлыг (цуваа цагт) хэлмэрчтэйгээр хийж ирсэн. 1998 оноос хойш хорь гаруй жил бараг 40 гаруй удаагийн хэвлэлийн хурлын хэлмэрчийн орчуулгад хийсэн нэгэн томоохон судалгааг Хятад улсын нэгэн докторант¹⁴ хийсэн. Бичгийн ба аман орчуулга нь дискурсын харьцууллын сонирхолтой харьцааг гаргахад энгийн нэгэн корпуст хийсэн шинжилгээнээс илүү их судалгааны орон зай ба мэдээллийг цуглуулах боломжтой. Нэг мэдээллийг хоёр дахин өсгөн хоёр үндэстний хэлний, нийгэм, соёл, улс төрийн орчны хэлний ялгаа, хэлний илэрхийлэмж, хэлзүйн зэрэгцүүлэл, үг хэллэгийн оноолт, хэлний дүйцэл зэргийг илрүүлэн гаргахын дээр нийгэм-соёлын, олон нийтийн санаа бодлын хандлага, үндэстэн тус бүрээр нэгэн ойлголт ухагдахууныг хэрхэн тусгаж авч байгаа зэргийг ч уг хэлний материалд тулгуурлан аргачлалаа сонгон, ямар ч өнцгөөс нь шинжлэн үнэлгээ өгч болдог. Орчуулгын судалгаанд энэ шинжилгээг хийснээр Норман Фейерклафын дискурсын 3 хэмжээст загварын аргачлалыг илүү боловсронгуй болгож баяжуулах, орчуулагч хэлмэрчээр зуучлагддаг эх ба орчуулгыг яаж шинжилж боловсруулалт хийх зэрэгт шинэ аргачлал боловсруулах шаардлагатай байгааг дүгнэсэн байна. Уг судлаач энэхүү тогтмол давтамжтай болдог хэвлэлийн бага хурлын хэлмэрч бол үзэл суртлын хоёр өөр фронтод ойлголцлыг бий болгох гэж ажилладаг гэдгийг тодотгожээ.

Энэ жишээнээс үзэхэд, орчуулгын сан бүрдүүлэх ажлыг олон жилийн турш бүрдүүлжээ. Судалгааны байгууллагын нэг хийгүүштэй ажил нь эх бичвэрийн сан үүсгэх юм. Тухайлбал, МУИС-ийн Ази судлалын тэнхимээс 1952-1962 онд орчуулагдсан Хятадын богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиолыг дахин эмхэтгэн гаргасан билээ. Зөвхөн хятад хэлнээс орчуулсан уран зохиолын сан үүсгэнэ гэвэл 1960-аад оноос хойш хятад тууж роман орчуулах явдал нэлээд дэлгэрч байсан, үүнээс өмнө богино хэмжээний уран зохиолын орчуулга голлож байжээ. Өнөө цагт орчин үеийн хятадын уран зохиолын орчуулга ч ар араасаа цувран гарч байна. Ардын хувьсгалаас өмнөх үеийн хятад уран зохиол ба сургаалын зохиолын орчуулга ч манайд их бий. Зарим хятад зохиол хэд хэдэн монгол орчуулгын хувилбартай. Ингээд зөвхөн хятадын уран зохиолын орчуулгын сан бүрдүүлсэн байхад хэдэн арван боть уран зохиолын орчуулгын бүтээл гарч болно. Энэ сан дээр цахим программаар шинжилгээ хийвэл монгол хэлний хөгжлийн байдал ба монгол ба хятад хэлний үгийн сангийн зэрэгцүүлсэн судалгаа, хятад ормол үг, авиа дуурайсан үг, дүйцэлгүй нэрийн судалгаа гээд тоймгүй олон судалгаа хийх боломжтой. Хэлшинжлэлийн бус, нийгмийн ухааны чиглэлээр олон судалгааг ч хийх боломж мөн бүрдэнэ. Тухайн үеийн нийгмийн байдал зохиолыг сонгож орчуулахад туссан, монгол уншигчийн сэтгэлгээний онцлогийг гаргах, хятадын соёлын зүйлийг цуглуулан шинжилгээ хийх, улс төр, нийгэм эдийн засгийн байдлын тусгал гээд юу эсийг ч шинжлэн гаргаж ирэх

¹⁴ Gu Chonglong, Rebecca Tipton (2020) (Re-)voicing Beijing's discourse through self-referentiality: a corpus-based CDA analysis of government interpreters' discursive mediation at China's political press conferences (1998–2017), *Perspectives, Studies in Translation Theory and Practice*, pp.1-18. ISSN: 0907-676X (Print) 1747-6623 (Online) Journal homepage: <https://www.tandfonline.com/loi/rmps20>

боломжтой. Энэ бол зөвхөн хятадын уран зохиолын орчуулгын сангаар жишээ болгож байгаа хэлний сан бүрдүүлэх тухай санаа юм. Бусад гадаад хэлнээс орчуулсан орчуулгын зохиолыг мөн хэл тус бүрээр сан бүрдүүлж энэ жишгээр судлах боломжтой.

Дүгнэлт

Орчуулгын үйл ажиллагаа бол ерөнхий хэлшинжлэл, тархи хэлшинжлэл, нийгэм хэлшинжлэлд хамаарах, орчуулагчийн мэдлэг боловсрол, хувь хүний сэтгэлзүй гээд олон хүчин зүйлийн үр дүнд буй болдог. Энэ үйл явцыг цогц байдлаар задлан шинжлэх боломжийг агуулдаг шинжилгээний нэг нь энэхүү олон хэлний материалын санд суурилсан дискурст хийх шүүмж шинжилгээ байх боломжтой гэж үзэж байна.

Хэлний материалын сан гэдэг бол судалгааны оногдохуун бөгөөд бүрдсэн сан баялаг их байх тусам судалгааны үр дүнгийн шинжилгээний хариу үнэнд илүү ойр, бодитой гаргах үндэс суурь нь болох юм.

Дискурсын шүүмж шинжилгээ бол зөвхөн шинжилгээ төдий бус нийгэм хэлшинжлэлийн дискурсыг судлах ухаан. Энэ ухаан хэлшинжлэлийн задлан шинжилгээний нэг төдийгүй, басхүү нийгмийн бүхий л хүрээний үйл явцыг дискурс хэлбэрт оруулж ямар ч аргаар судлах боломжтой шинжилгээний арга хэрэгсэл юм.

Орчуулгын (бичгийн) болон хэлмэрчлэхүйн (ярианы) хэлбэрээр илэрч буй дискурс тодорхой юмс, үзэгдлийн хоёр ба түүнээс дээш хэлний илэрхийллээр илэрхийлэгддэг дискурс болох тул дискурсын шүүмж шинжилгээний загварыг илүү баяжуулан, өөр өөр үндэстний соёлын ба нийгэм, улс төрийн хоорондоо давхцалгүй, ялгамжаат хүчин зүйлийг илрүүлэн гаргаж шинжлэх боломжтой болгодог.

Номзүй

1. Дэлхийд түгсэн Монголын Нууц Товчоо, МУИС, МСХ, УБ, 2016, Мөнхийн үсэг ХХК
2. Монголын нууц товчоо зохиолын гадаад орчуулга, УБ, Бемби сан ХХК
3. Мөнх.Н (2015) МНТ-ы өнгө, зүсэм бүхий хүний нэрийн франц орчуулга, Гадаад хэл соёл судлал, МУИС ЭШБ, Боть 19(430) , 108-114 тал.
4. Ferdinand de Saussure, (1916) Cours de Linguistique Гийнрале, Librairie Payot & C, Lausanne-Paris
5. Van Dijk, T.A.(1993). Elite Discourse and Racism. Newbury Park, Calif: Sage Publications. Inc
6. Fairclough, Norman. (1989). Language and Power. New York: Longman. [SEP]
7. Fairclough, Norman (1993) Critical discourse analysis and the marketization of public discourse: Universities. Discourse and [SEP]Society, 4 (2), 133-168. [SEP]
8. Fairclough Norman. (1995) Text and Language, *Critical Discourse Analysis*. (London, Longman)

9. Tian Xinling (2018) Critical Discourse Analysis of News Reports— Based on the Guardian News Report of China’s Military Parade to Mark the 70 Years of Second World War, *Theory and Practice in Language Studies*, Vol. 8, No. 4, pp. 433-444
10. Winnie Cheng (2013) Corpus-Based Linguistic Approaches to Critical Discourse Analysis, *Research Gate*, 1-8 pp.
https://www.researchgate.net/publication/262070226_Corpus-Based_Linguistic_Approaches_to_Critical_Discourse_Analysis
11. Gu Chonglong, Rebecca Tipton (2020) (Re-)voicing Beijing’s discourse through self- referentiality: a corpus-based CDA analysis of government interpreters’ discursive mediation at China’s political press conferences (1998–2017), *Perspectives, Studies in Translation Theory and Practice*, pp.1-18 ISSN: 0907-676X (Print) 1747-6623 (Online) Journal homepage: <https://www.tandfonline.com/loi/rmps20>
12. *The Routledge Handbook of Language and Identity* (2016), Routledge, London & New York
13. *Systematic Functional Linguistics and Critical Discourse Analysis: Studies in Social Change* (2004), Lynne Young and Claire Harrison, London & New York